ЦАГААННУУР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.

2018.12.06

2018 онд Эрүүл мэндийн салбараас “**Эрүүл мэндийн даатгалыг –Иргэн бүрт**” гэсэн уриа дэвшүүлэн ажилласан. Эрүүл мэндийн төв нь 2018 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

НЭГ: УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХАНГАМЖ, ХҮРЭЛЦЭЭ, ЧАДАВХИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР:

Эрүүл мэндийн төв нь хүн амын тооноос хамааран 4-р зэрэглэлийн ангилалын дагуу 25 хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар батлагдсан. 2018 онд ажлын байранд шинээр их эмч 2, эмийн бус эмчилгээний сувилагч 1-ийг авч ажиллуулсан. Одоогийн байдлаар: их эмч 4, эх баригч бага эмч 1, дүн бүртгэгч бага эмч 1, НЭМ-ийн ажилтан 1, эмийн бус эмчилгээний сувилагч 1, дархлаажуулалтын сувилагч 1, ахлах сувилагч 1, ээлжийн сувилагч 4, лаборант 1, эмийн санч 1, нярав угаагч 1, үйлчлэгч 4, тогооч 1, жолооч 2, бүгд 25 ажилтантайгаар сумын хүн амд эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлж байна. Дутагдалтай байгаа орон тоонд эмэгтэйчүүдийн их эмч шаардлагатай байна.

Удирдлага зохион байгуулалтын хувьд: Удирдлагын баг, Чанарын баг, Ёс зүйн баг, Халдварын сэргийлэлт, хяналтын баг, Сувилахуйн нэгж, Хог хаягдлын менежментийг сайжруулах багууд тус бүр ажиллаж үйл ажиллагаагаа явуулж байна.

2018 онд хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэхэд ажлын байран дахь сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнийг чадавхжуулах “Цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн байдлыг эрүүлжүүлэх” сэдэвт сургалтанд их эмч Э.Батхишиг, “Элэг бүтэн Монгол-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтанд их эмч Э.Батхишиг, лаборант У.Ууганбаяр, сувилагч З.Хулан, Б.Бумдарь нар, “Олныг хамарсан осол, гэмтлүүдийн үеийн яаралтай тусламж үйлчилгээ”, их эмч Э.Батхишиг, “Нэг иргэн-Нэг бүртгэл” сэдэвт сургалтанд их эмч Э.Батхишиг, эх баригч бага эмч М.Мөнхзул, дүн бүртгэгч бага эмч В.Туулцэцэг, вакцинатор Б.Бумдарь нар тус тус хамрагдсан. “Эмийн зохистой хэрэглээ” сэдэвт сургалтанд эмийн санч Э.Энхтуяа хамрагдсан. “Эрүүл мэндийн тусламж

үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн мэргэжилтнтй ёс зүй, уламжлалт анагаах ухаанытусламж үйлчилгээг сайжруулах" сургалтанд их эмч Э.Батхишиг хамрагдсан. 2018 оны 12-р сарын 07-08-ны өдрүүдэд болсон "Бид Сэлэнгий ирээдүй" сэдэвт аймгийн хөтөлбөр хэрэгжүүлэх нөлөөлийн сургалт болон "Эх хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах нь" сэдэвт их эмч нарыг чадавхжуулах сургалтанд Эрүүл мэндийн төвийн дарга Ж.Оюунчимэг хамрагдсан. "Эрүүл мэндийн бүртгэл мэдээллийг сайжруулах нь" сэдэвт сургалтанд дүн бүртгэгч бага эмч В.Туулцэцэг, "Нягтлан бодогч нарыг чадавхжуулах" сургалтанд нягтлан С.Атарцэцэг нар хамрагдсан. 2018 онд их эмч Г.Баттулга ЭХО-ны 3 сарын сургалтанд суралцаж байна.

2018 оны 11-р сарын 24-ны өдөр "Эм хангамжийн салбар үүсч хөгжсөний 90-н жилийн ойн баяр"-ын арга хэмжээнд эмийн санч Э.Энхтуяаг оролцуулсан.

2018 онд Эмнэлгийн ажилчдын баяраар Эрүүлийг хамгаалахын "Тэргүүний ажилтан"-аар бага эмч А.Энхдэлгэр, сувилагч Ч.Болорсайхан, Эрүүл мэндийн яамны "Жуух"-аар сувилагч Б.Цолмон, үйлчлэгч Д.Мягмаржав нар шагнагдсан.

ХОЁР: ЭМНЭЛГИЙН БОЛОН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР:

Үйлчлэх хүрээний хүн амд эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй, түргэн шуурхай, жигд хүртээмжтэй хүргэхэд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд ажлын байрны тодорхойлолтонд заагдсаны дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар:

2018 онд амбулаторийн үзлэг 5503, урьдчилан сэргийлэх үзлэг 1812, идэвхтэй хяналтыг 566, гэрийн эргэлтийг 178 хүнд тус тус хийсэн байна.Түргэн тусламжийн 2261 дуудлаганд хүрч үйлчилснээс алсын дуудлага 135, осол гэмтлийн дуудлага 40 эзэлж байна. Амбулаториор болон эмнэлэгт хэвтэн эмчлэгдсэн 4306 үйлчлүүлэгчийг хүлээн авах, асуумж авах, үзлэг хийх, өвчний түүх, үйлчлүүлэгчийн эмнэлгийн карт, эрүүл мэндийн дэвтэр болон бусад холбогдох баримт бичгүүдийг стандартын дагуу байнга тогтмол хөтөлж ирсэн.

2018 оны 2-р сард Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан "Халдварт бус өвчний эрт илрүүлэг"-ийн үзлэгт сумын 1200 иргэд хамрагдсан.

2018 онд артерийн гипертензи өвчний эрт илрүүлэг үзлэгт нийт 1035 хүнийг хамруулснаас 51 хүн шинээр оношлогдсон, чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 1001 хүн хамрагдсанаас 2 хүн шинээр оношлогдсон.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/196 тоот тогтоолоор баталсан ”Элэг бүтэн Монгол”-2 үндэсний хөтөлбөрийн хүрээнд элэгний В, С вирусын илрүүлэг, шинжилгээнд 15-39 нас, 2017 онд “Элэг бүтэн Монгол”-д хамрагдаагүй 40-65 насны иргэд, 65-аас дээш насны иргэдийг элэгний В, С вирусын илрүүлэг шинжилгээнд идэвхтэй хамруулах, шинжилгээнд хамрагдахын ач холбогдлын талаарх мэдээлэл, сурталчилгааг хороо баг хариуцсан эмнэлгийн ажилтан, нийгмийн ажилтаны оролцоотойгоор эрт илрүүлгийн шинжилгээг чанартай чирэгдэлгүй зохион байгуулсан.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлсөн 15-39 нас, 65-аас дээш насны 1061 иргэдийг элэгний В, С вирусын илрүүлэг шинжилгээнд хамруулж, Health.gov.mn программд бүртгэж баталгаажуулсан. Оношлогоонд хамрагдах хүсэлтэй даатгалгүй иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг сумын нийгмийн даатгалын байцаагчтай хамтран ажиллаж, 52 хүнийг даатгалд хамруулсан.



Шинжилгээнд хамрагдах иргэдийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 5-р сарын 18-ны өдрийн А/196 тушаалын гуравдугаар хавсралтанд баталсан “Хепатит вирусын халдварын эрт илрүүлгийн мэдээлэх хуудас”-аар шинжилгээ өгөх зөвшөөрлийн хуудсаар зөвшөөрөл авч, 15-39 насны 928, 40-65 насны 67, 65-аас дээш насны 66, нийт-1061 хүнийг шинжилгээнд хамруулж, программд шивж оруулсан. Шинжилгээнд хамрагдсан 1061 хүнээс **С вирус сул эерэг гарсан нийт 34**, үүнээс / 15-39 насанд 17, 40-65 насанд 4, 65- аас дээш насанд 13/ **В вирус сул эерэг гарсан**

нийт 58, үүнээс /15-39 насанд 50, 40-65 насанд 4, 65-аас дээш насанд 4/. Шинжилгээнд хамрагдалтын мэдээг 2018 оны 10-р сарын 5-ны өдрөөс эхлэн өдөр бүр хугацаанд нь аймгийн Нэгдсэн эмнэлгийн дүн бүртгэгчид өгч байсан. Эрүүл Мэндийн Сайдын А/196-р тушаалын хавсралтанд заасан маягтуудыг цаг тухайд нь хөтөлсөн. 196-р тушаалд заасан хавсралт 2 буюу шинжилгээнд хамрагдах зөвшөөрлийн хуудсыг 2 хувь гаргаж, 1 хувийг шинжилгээ өгсөн хүнд, 1 хувийг нь эмнэлэгт үлдсэн.

Эх хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр:

Эхийн тусламж үйлчилгээг батлагдсан “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний 4 дэх хөтөлбөр, ”Эх нярайн эрүүл мэнд” стратеги, Мянганы хөгжлийн 4,5 дугаар зорилт болон бусад стандарт, журам, заавар, удирдамжийн дагуу үзүүлж ирсэн. ЭМС-ын 2014 оны №338 тоот тушаалын дагуу “Жирэмсэн, төрөх,төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журам-ыг баримтлан ажилласан. 2018 онд жирэмсний хяналтанд нийт 102 эх хяналтанд орсноос эхний 0-3 сар дотор 102 буюу 88,2% нь эрт үеийн хяналтанд орсон байна. Жирэмсний хяналтанд шинээр орсон 102 жирэмсэн эмэгтэйчүүдийн өртөмтгий байдлыг үнэлэхэд хөнгөн зэрэгтэй 64, өртөмтгий 38 жирэмсэн эмэгтэй байна. Ялангуяа гаднаас түр оршин суугаа 5 жирэмсэн эхчүүдийг чирэгдэлгүй хүлээн авч хяналтандаа авч анхааралдаа авч ажилласан ба харьяа дүүргийн өрхийн эмч нартай утсаар холбоотой ажиллаж байна.

2018 онд жирэмсний хяналтанд 102 эх хамрагдаж байгаа бөгөөд үүнээс хөдөөгийн багт 55 эх хянагдаж байна. “Багт хүрч ажиллах” уриа дэвшүүлж хөдөөгийн алслагдсан багийн эх хүүхдэд сард 1 удаа гэрийн идэвхитэй эргэлтийг багийн эмч нартай хамтарч нийт 4 удаа гэрийн идэвхитэй эргэлтийг давхардсан тоогоор 84 эхэд явуулж, НҮ-н багц тусламж үйлчилгээг явуулж хэвшлээ. Өндөр эрсдэлтэй бүлгийн болон онцгой хяналтын жирэмсэн 38 эмэгтэйчүүдийн талаар аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн эмч Т.Сэлэнгээ, Цогтбаатар, Энхбаяр, Мөнхзул, Алтанцэцэг, Оюунцэцэг эмч нараас тогтмол утсаар зөвлөгөө авч ажиллаж байна. Эдгээр эмэгтэйчүүдийн 31 эх нь хүндрэлгүй амаржсан байна. Сумын эмнэлэгт нийт 62 жирэмсэн эмэгтэйчүүд хэвтэж эмчлүүлснээс сумын эрүүл мэндийн төв дээр шээсний ерөнхий, цусны ерөнхий, мозак, тэмбүү, ХДХВ-ийн шинжилгээнүүдэд 100% хамруулж, нийт 158 эмэгтэйг шинжилгээнд хамруулсан байна.

Тэмбүүгийн шинжилгээ эерэг гарсан 2 жирэмсэн эхийг хавьтагчийн хамт эмчлэн эрүүлжүүлсэн. 2018 онд аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт 88 эх, суманд 15 эх төрсөн. Гараас гарт шилжүүлэх зарчмыг чанд сахиж ажилласан.

2018 онд нийт 103 эх амаржснаас 22 эх кесар хагалгаагаар, 81 эх төрөх замаар төрлөг явагдсан байна. 2-догч шатлалын эмнэлэгт шилжүүлэхдээ холбогдох нарийн мэргэжлийн эмч нартай урьдчилан утсаар мэдэгдэж 88 эх зөөвөрлөсөн байна. Эхийн эндэгдэл болон гэрийн төрөлт гаргаагүй ажиллаж байна.

Умайн хүзүү, хөхний хавдар эрт илрүүлгийн үзлэгт хамрагдах зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн судалгааг овог нэр, регистрийн дугаараар гаргахад үзлэг шинжилгээнд 212 эмэгтэй хамрагдахаас 156 эмэгтэй үзлэг шинжилгээнд хамрагдсан ба хамралтын хувь 73,5%-тай байна. байна. Хяналтанд орж байгаа жирэмсэн эмэгтэйчүүдийг нарийн мэргэжлийн эмч нарын бүрдмэл үзлэг шинжилгээнд 1-2 удаа 100% хамруулж байгаа бөгөөд шаардлагатай тохиолдолд давтан нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээнд тухай бүр нь хамруулж байна.

Гэр бүл төлөвлөлтөнд эмзэг бүлгийн болон өртөмтгий бүлгийн нийт эмэгтэйчүүдийг хамруулсан ба эмэгтэйчүүдийн 92% нь жирэмслэхээс сэргийлэх аргыг хэрэглэж байна. Төрөх насны эмэгтэйчүүдээс өндөр эрсдэл бүхий архаг өвчтөй 75 эмэгтэйгээс 69 эмэгтэйд, хөгжлийн бэрхшээлтэй 75 эмэгтэйгээс 70 эмэгтэйд, амьжиргааны түвшин доогуур 38 эмэгтэйгээс 33 эмэгтэйд, тус тус жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргыг хэрэглүүлсэн байна. Нийт 598 эмэгтэйд жирэмслэхээс сэргийлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгааг хийсэн байна. “Эрүүл гэр бүлээс-Эрүүл хүүхэд” уриан дор жирэмсэлтэд бэлтгэх багц тусламжийг нэвтрүүлэх арга замыг эхлүүлж байна. Сүрьеэ өвчнөөр өвдөж байсан эмэгтэйчүүдийн судалгааг гаргахад нийт 20 эмэгтэй байгаа бөгөөд ГБТ-ийн 18 эмэгтэйд хэрэглүүлж байна. Эхийн амрах байраар алслагдсан багийн нийт 27 эх амарсан байна. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд жирэмсний хяналтанд эрт орохын ач холбогдол, төмөр фолийн хүчил,жирэмсэн үед илрэх

аюултай шинж тэмдэг,үр хөндөлт, БЗДХ-ын талаар мэдээлэл сургалт сурталчилгааг 115 жирэмсэн эмэгтэйд хийж, мэдээлэлийн 4ш самбар шинээр хийж тогтмол байрлуулан ажиллуулав. Эмнэлгийн үзлэгийн өрөөнд болон яаралтай дуудлагын багцад жирэмсний сорилыг тогтмол бэлэн байлгаж ажиллаж байна.

0-15 насны хүүхдийн эндэгдэлгүй ажилласан бөгөөд хүндэвтэр, хүнд 0-5 насны хүүхдийн биеийн байдлыг аймгийн хүүхдийн эмч нарт танилцуулж эмчилгээний зөвөлгөө авахаас гадна тээвэрлэх эсэхийг шийдвэрлэж тухайн өвчний хүндэрлээс урьдчилан сэргийлж ажилладаг. 0-5 насны гэрийн эргэлт 68 удаа хийсэн. Мөн сургуулийн насны 795 хүүхдийг ам залгиурын үзлэгт хамруулсан. Үүнээс 91% нь шүдний өвчлөлтэй, 34% дунд чихний архаг үрэвсэлтэй, 12% харшилтай, 78% хоолойн ангинатай байна.487 хүүхдэд А аминдэм тараасан.

2. Дархлаажуулалтын талаар:

2018 онд хүүхдийн товлолт вакцинд эмнэлэгт төрсөн 15 хүүхдэд БЦЖ, В гепатит, саагийн, 2 сартай 117 хүүхэд, 3 сартай 114 хүүхэд, 4 сартай 109 хүүхэд 5-т болон саагийн вакцин, 9 сартай 120 хүүхдэд УГУ, 1 нас 2 сартай 120 хүүхдэд А гепатит, 2 настай 91 хүүхдэд УГУ, А гепатит, 6 сартай 16 хүүхдэд улаан бурханы вакцин, 7 настай, 15 настай хүүхдэд сахуу, татрангийн 2-т вакциныг 169 хүүхдэд, нийт 871 хүүхдийг тус тус хамруулсан байна. Менингококкийн вакцинд цэцэрлэгийн 2-5 насны нийт 30 хүүхдийг хамруулсан.

2018 онд хачигт халдварын вакцины 1-р тунг 97 хүнд, 2-р тунг 93 хүнд, 3-р тунг 84 хүнд, сэргээх тун 148 хүн нийт 422 хүнд, галзуугийн вакциныг 23 хүнд,

улаан бурханы вакциныг төрсөн 15 эхэд тус тус хийсэн. Сүрьеэгийн сорилыг сүрьеэгийн хавьтлын 21 хүнд тавьсан. Эмнэлгийн ажилчид, эмзэг бүлэг, жирэмсэн нийт 50 хүнийг томуугийн вакцинд хамруулсан.

Дархлаажуулалтанд хамрагдвал зохих хүүхдийн нэрсийг 0-15 насны хүүхдийг дархлаажуулалтанд хамрагдах бүртгэлээс товлолын дагуу түүж төлөвлөдөг. Сар бүрийн эхний 7 хоногт төлөвлөгөөний дагуу захиалга хийж, вакциныг аймгийн ЭМГ-аас татан авдаг. Заавал хийх дархлаажуулалтын мэдээг сар бүрийн 1-ний дотор аймгийн ЭМГ-ын дархлаажуулалтын албанд мэдээлдэг.

3. Лабораторийн үйл ажиллагааны талаар:

2018 онд лабораторийн үйл ажиллагааг хэвийн явуулснаар цусны ерөнхий шинжилгээг 550 хүнд, шээсний ерөнхий шинжилгээг 1230 хүнд, цагаан хорхойн шинжилгээг цэцэрлэгийн 230 хүүхдэд, B,C вирус илрүүлэх шинжилгээг 1061 хүнд, цусны болон резус бүлгийг 127 хүнд, сүрьеэгийн шинжилгээг 35 хүнд, сахарын шинжилгээг 146 хүнд, БЗДХ, ХДХВ/ДОХ-ын шинжилгээг 196 хүнд, хеликобактерийн шинжилгээг 35 хүнд тус тус хийсэн байна**.** Цэргийн насны

залуучуудын 2 удаагын цэрэг татлагаар Шээсний ерөнхий шинжилгээ, цусны ерөнхий шинжилгээ, цусан дахь өлөн үеийн глюкоз, цусны бүлэг,резус бүлэг, БЗХӨ Дох, HVC HB_sAg, хийсэн.

Үйлчлүүлэгч бүрд шинжилгээг өгөхөөс өмнө шинжилгээ тус бүрээр зөвлөгөөг тогтмол өгч ажилладаг. Оношийн үндэслэлийг зөв гаргахын тулд хэвтэн эмчлүүлэгч бүрт шинжилгээг хийж, өвчний түүхэнд хавсаргадаг.

4. Сувилахуйн тусламж үйлчилгээний талаар:

Сувилахуйн нэгж нь ахлах сувилагч Ч.Алтанзулаар ахлуулан сувилагч 6, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 7, нийт 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр хүн амд сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлж байна.



2018 онд эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 516 хүнээс 28 хүнд асаргаа сувилгааг хийсэн. 35 хүүхдэд утлага, гич, 32 удаагийн шархны анхдагч цэгцлэлт, гэрийн идэвхтэй эргэлтийг 28 удаа, төрсөн эхэд үзүүлсэн тусламж 15, хэвтрийн болон хүнд өвчтөнд үзүүлсэн тусламж 15, цэвэр боолт 82 удаа, цэвэрлэх бургуйг 21 удаа тавьсан. Хэвтрийн болон хүнд өвчтөний гэрийн эргэлт, асаргаа сувилгааг 2, 3-р багийн 12 иргэдэд хийж, витаминжуулсан. Сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх орчин нөхцлийн үнэлгээ хийхэд сувилагч нарт амбулаторын тариа хийх өрөө дутмаг, сувилгаа хийхэд зориулагдсан бойлуур, халуун усны өрөө хангалтгүй байна.

Сувилагчдын үйлчлүүлэгчдийн биеийн байдлыг үнэлэх чадварт үнэлгээ өгөхөд шаардлагатай чагнуур 1 ширхэг, даралтны аппарат 1 ширхэг, халууны шил 4 ширхэг, жигут 4 ширхэг, пульс оксиметр 1 ширхэгийг тус тус авч, тусламж үйлчилгээндээ ашиглаж байна.

Сувилахуйн тусламж үйлчилгээний өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, тойрон үзлэгийг өдөр бүр хийснээр алдаа зөрчлийг илрүүлэн, арга хэмжээг тухай бүр авч шийдвэрлэн ажиллаж байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой өдөр тутмын болон эх хүүхдийн мэдээг өдөр бүр Эрүүл мэндийн газарт тогтмол мэдээлж байна. Эмнэлгийн ажилтан болон сувилагч нарт яаралтай тусламжийн тоног төхөөрөмжтэй хэрхэн ажиллуулах болон зүрхний цахилгаан бичлэгт хэрхэн хийж, унших талаар сургалтыг их эмч Э.Батхишиг зохион байгуулсан. Хүнд өвчтэй хэвтрийн өвчтэй хүмүүст гэрээр нь

очиж, зүрхний цахилгаан бичлэгийг хийж, эмнэлгийн тусламжийг цаг алдалгүй хөнгөн шуурхай үзүүлсэн.

Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд дотоодын сургалтыг нийгмийн эрүүл мэндийн ажилтан Б.Шинэтуяа, ахлах сувилагч Ч.Алтанзултай хамтарч, хуваарийн дагуу нийт 22 удаа зохион байгуулсан Эмийн бус эмчилгээний тусламж үйлчилгээг стационарт хэвтэн эмчлүүлж байгаа болон амбулаториор үйлчлүүлж байгаа иргэдэд стандартын дагуу чанартай, аюулгүй, түргэн шуурхай үзүүлж байна.

Эмийн бус эмчилгээнд уламжлалт анагаахын сувилагч орон тоогоор ажиллаж байна.



2018 онд шарлагын УВЧ аппарат, Искра аппарат, ультра туяа, татлагын ор, хөлний массажны аппарат зэрэг багаж төхөөрөмжүүдийг шинээр ашиглалтанд

оруулсан. 2018 онд амбулаторын эмийн бус эмчилгээг нийт 1059 хүнд, стационарын эмчиилгээг нийт 943 хүнд тус тус хийж үйлчилсэн.

Үүнээс: Бариа засал нийт 510 хүнд, бумба 480 хүнд, зөгийн балтай татлага 30 хүнд, Искра аппаратаар 205 хүнд шарлага, Биоптрон аппаратаар 90 хүнд шарлага УВЧ аппаратаар 370 хүнд, утлага (будасон бодис) давхардсан тоогоор 176 хүнд, массажны сандлаар 70 хүнд тус тус үйлчилгээ үзүүлсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон харвалттай хүмүүст сэргээн засах дасгал хөдөлгөөнийг зааж, ар гэрийнхэнд нь зөвлөгөө өгч ажилласан.

5. Статистик мэдээллийн талаар

Эмнэлгийн бүртгэлийн болон тайлангийн маягтыг 2013 оны ЭМС-ын 450 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу нийт хөтлөгдвөл зохих 83 анхан шатны бүртгэлийн маягтыг стандартын дагуу үнэн зөв хөтөлсөн. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн бүртгэлийн болон тайлангийн маягтын үнэн зөв, бүрэн хөтөлсөн байдалд сар бүр дотоодын хяналт хийж, гаргасан зөрчлийг тухай бүр арилгуулж, арга зүйгээр ханган ажилласан.

Health info программ дээр сумын хүн амыг шивж мэдээллийн сан үүсгэж, төрөлт, нас баралт, эх хүүхдийн эндэгдэл, амбулаторийн болон стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлтийг өдөр бүр СТ-12, АМ-1Б маягтаар авч нэгтгэн, сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон нэгтгэж, дараа сарын 1-ний өдөр ЭМГ-ын статистик мэдээллийн албанд мэдээлдэг. 2017 оны жилийн эцсийн мэдээ тайланг 2013 оны ЭМС-ын 450 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу цаасан болон цахим хэлбэрээр гарган 2018 оны 1-р сарын 07-ны өдөр тогтоосон хугацаанд нь ЭМГ-ын статистик мэдээллийн албанд өгч хангалттай сайн үнэлгээг авсан.

2018 онд H-INFO программд өвчтөний түүх 520, эмчийн үзлэг 5503, төрөхөөс гаргагч 15, эмнэлгээс гаргагч 516, нас баралт 19, халдварт бус өвчлөл 894, осол гэмтэл 33 тохиолдлыг тус тус шивж, цахим мэдээний санг үүсгэсэн. Хүн амын төрөлт, нас баралт, өвчлөлийн мэдээ, шинээр бүртгэгдсэн жирэмсэн, нэг цэгийн мэдээг сар бүрийн 1-ний өдөр ЭМГ-т үнэн зөв, хугацаанд нь бүртгэж мэдээлсэн. Амбулаторийн болон стационарын томуугийн мэдээг 7 хоног бүрийн Баасан гаригт эмч нарын үзлэгээс авч, ЭМГ-ын халдвар судлалын албанд мэдээлдэг. Сүүлийн 5-н жилийн байдлаар хүн амын өвчлөл, нас баралтын эхний 5 шалтгаанаар судалгаа гаргаж, эмч ажилчдад танилцуулж, дүн шинжилгээ хийсэн.

Эмнэлгийн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийг жил бүрээр гарган, мэдээллийн самбарт байрлуулан, ард иргэдэд танилцуулж, мэдээлэл хийсэн.

Албан бичгийг хэвлэмэл хуудсанд стандартын дагуу ашиглаж, тамга тэмдгийн зөв хэрэглэх, байгууллагын бичиг баримтыг стандартын дагуу хөтлүүлэх, архивд хадгалагдаж байгаа бичиг баримтыг эмхлэн цэгцэлж, бүртгэл хийсэн. Эмнэлэгт хөтлөгдөж байгаа баримт бичгийн эмх цэгцийг ханган ажиллаж, ирсэн явсан албан бичгийг бүртгэн хариутай бичгүүдийг хугацаанд нь барагдуулж ирсэн.

6. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр:

Тус Эрүүл мэндийн төв дээр 2018 оны 10–р сарын 15-ны өдрөөс 10-р сарын 25-ны өдрүүдэд “Томуугийн эсрэг дархлаажуулалт” уриан дор дархлаажуулалтын 10 хоногийн аяныг зохион байгуулав. Дархлаажуулалтын аяны хүрээнд томуугийн эсрэг вакцинаар ахмад настан 26 , жирэмсэн эхчүүд 31, архаг суурь өвчтөй 13 , зорилтот бүлгийн 7 нийт 77 хүн амыг томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулав. Алслагдсан багийн 15 өрхөөр явж, товлолт вакциныг 5 хүүхдэд, жирэмсэн 8 эхэд, ахмад настан 2 хүнд томуугийн вакциныг хийв. “Томуу, томуу төст өвчин урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын ач

холбогдол” сэдвээр 60 хүүхдэд, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа 15 хүнд сургалт хийсэн.

2018-оны 12-р сарын 03-ны өдөр “Тархины харвалттай тэмцэх” өдрөөр тархинд цус харвах өвчин нь залуужиж байгаатай холбоотойгоор өвчний талаар олон нийтэд сургалт, сурталчилгаа олон нийтийн газар зурагт хуудас байршуулсан. “Тархинд цус харвах шалтгаан, сэргийлэлт, цусны даралт ихсэх харвасаны дараа булчин суллах, чангалах, иллэг, цэгэн бариа” сэдвээр сургалтыг хөгжлийн бэрхшээлтэй 15 хүнд явуулсан. Сумандаа амьдарч байгаа харвасан хүмүүсдээ болон ар гэрийнхэнд нь харвалтын дараах сэргээн засах дасгал хөдөлгөөнийг зааж өгсөн. Их эмч Э.Батхишиг, Их эмч Г.Баттулга, Ахлах сувилагч Ч.Алтанзул, Сувилагч Ч.Болорсайхан нар хэвтрийн хүмүүст асаргаа сувилгаа хийж зөвөлгөө өгөв.

Олон улсын ахмадын өдрийг 2018 оны 10-р сарын 1-ний өдрөөс 10-р сарын 15-ны өдрүүдэд “Сүрьеэг бууруулахад настны оролцоо” сэдэвт 14 хоногийн аяныг зохион байгуулж, нийт 50 өндөр настангуудыг урьдчилсан үзлэгт хамруулсан. Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан байгууллагаас тэтгэвэрт гарсан нийт 12 ахмадуудыг цайлж гарын бэлэг өгсөн.

Их эмч Э.Батхишиг, их эмч Г. Баттулга, ахлах сувилагч Ч.Алтанзул, сувилагч З. Хулан нар хэвтрийн 5 ахмадад асаргаа сувилгаа хийж зөвөлгөө өгөв.

Эрүүлжүүлэх, залуужуулах дасгалыг ЭМТ-ийн ажилтан 18, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа 14 хүнд зааж өгсөн. ЭМГ-аас зохион байгуулж буй “Эрүүл зөв дадал хэвшилтэй эмч, эмнэлгийн ажилчид” спортын тэмцээнд сувилагч Ч.Болорсайхан, үйлчлэгч Б.Гоёхончимэг, жолооч Д.Мягмарсүрэн нарыг тэмцээнд оролцуулсан.

2018 оны 11-р сарын 15-ны өдрөөс 12-р сарын 1-ны өдрүүдэд “БЗДХ, ХДХВ” - эрт илрүүлэгийн үзлэг зохион явуулж 14 хоногийн аяныг зохион байгуулав. “БЗДХ, ХДХВ” аяны хүрээнд нөхөн үржихүйн, ард иргэдийн дунд дох, тэмбүүгийн шинжилгээнд 250, өсвөр үеийнхэний дунд БЗДХ-ын талаар сургалтыг 100, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд БЗДХ-ийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд БЗДХ-ийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах 300, ард иргэд, нийт 650 хүнийг хамруулсан, олон нийтийн газарт зурагт хуудас байршуулсан. “БЗДХ, ХДХВ” –ийн аяны хүрээнд хөтөлбөрөөс 867500₮ төгрөгийг зарцуулсан.

7. Эм хангамжийн талаар:

Цагааннуур сумын ЭМТ-ийн эмийн сан нь 2018 онд нийт 22.300.0 төгрөг эмийн төсөвт батлагдсан ба үүний 100% буюу 22.300.0 төгрөгний эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материалд Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газарт тендерийн захиалга хийсэн.

Одоогийн байдлаар тендерээр ирэх эм тарианы 90% буюу 17,261,404 төгрөгний эм тариа, бараа материалыг татан авч сумын эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдэд хэрэглэсэн байна. Эмийн сан нь Сэлэнгэ аймгийн Монос ЭХНБ, Улаанбаатар хотын Дакал фарм ЭХНБ-тай гэрээ хийж, нийт 630475 төгрөгний эм бараа материал татан авч сумын ард иргэдэд хөнгөлттэй эмийн жороор болон жортой жоргүй олгох эмээр үйлчилсэн.

Хөнгөлттэй эмийн жороор 500 ард иргэд нийт 10.000.0 төгрөгний жоргүйгээр 2.741.000 эм бараа материалаар үйлчилсэн.

Хөдөөгийн болон алслагдсан айл өрхөөр явж эм, эмнэлгийн хэрэгслийн борлуулалт хийсэн ба ”Эм хоол ундны хамаарал”, Хуурамч эм” “Антибиотек эмийн хэрэглээ”, “Эмийн гаж нөлөө” сэдвүүдээр яриа танилцуулга, мэдээ мэдээлэл хийв.

ТАЙЛАН ГАРГАСАН: ДАРГА Ж.ОЮУНЧИМЭГ